



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

додд. од. 21 № 1-6/81

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	222.9	289.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	510.2	452.9
	Нийт хөрөнгийн дүн	733.1	742.5
	Нийт өр төлбөрийн дүн		5.6
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	733.1	736.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	733.1	742.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,255.6	1,170.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,059.4	1,166.5
	Үйл ажиллагааны үр дүн	196.2	3.8
	Үйл ажиллагааны бус үр дүн		-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	196.2	3.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536.9	733.1
	Тайлант оны үр дүн	196.2	3.8
	Эцсийн үлдэгдэл	733.1	736.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,125.3	1,132.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,075.3	1,103.6
	Үйл ажиллагааны ЦМГ	50.0	28.7
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(37.1)	(27.3)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	12.9	1.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15.3	28.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28.2	29.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	977.3	971.6
	Урсгал зардал	977.3	971.6
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	977.3	1,020.1
	Улсын төсвөөс санхүүжих	977.3	1,020.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь “Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг болон олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, чанартай ажил, үйлчилгээг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бизнес эрхлэгчийн таатай орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” чиг үүрэгтэй байна.

Мэргэжлийн хяналтын газар нь стратеги төлөвлөгөөнд зорилтыг дараах байдлаар тодорхойлж, тусгасан байна. Үүнд,

- Мэргэжлийн хяналтын талаарх хууль тогтоомж, хяналт шалгалтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;

- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг зохион байгуулах;
- Мэргэжлийн хяналтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын стандарт, нийтлэг шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Иргэдийг эрүүл аюулгүй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, хууль тогтоомжийг нийтийн хүртээл болгох;
- Байгууллага, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын эрхзүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

МХЕГ-аас 2021 оныг “Дижитал-шилжилт хэрэглэгчтэй хамтарсан хяналт”-ын жил болгон зарласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид, эд хөрөнгө, байр зэргийг гаалийн байгууллагад шилжүүлж, бүтцийг өөрчлөн батлахаар тусгасан байна. Үүнтэй холбоотойгоор Хатанбулаг сум дахь Ханги хилийн боомтын нэгжид харьяалагдах 5 албан хаагч, мөн тус нэгжийн хөрөнгийг гаалийн байгууллагад 2022 онд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Тус байгууллага нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд Интерактив ХХК-ний Эмиралд санхүүгийн программыг ашигладаг. Уг программаас ерөнхий журналыг эксел программд хөрвүүлэхэд орлого, зарлагын гүйлгээг бүрэн хуулдаггүйн улмаас орлого, зарлагын нийт дүн санхүүгийн тайланд тусгасан мэдээллээс зөрүүтэй байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллагад бүртгэлтэй, тус бүр нь 43.7 сая төгрөгийн анхны өртөг бүхий, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Мицубиши Пажеро маркийн суудлын 2 автомашиныг худалдан борлуулах шийдвэрийг ТӨБЗГ-аас ирсэн. Үүний дагуу дуудлага худалдааг зарласан. Дуудлага худалдааны доод үнийг 0.5 болон 1.5 сая төгрөгөөр автомашин тус бүрээр тогтоосон байна. Дуудлага худалдаагаар доод үнэ 0.5 сая төгрөг бүхий автомашиныг 0.55 сая төгрөгөөр борлуулж, балансаас хассан байна. Доод үнэ 1.5 сая төгрөгөөр тогтсон автомашиныг борлуулах дуудлага худалдааг 2 удаа зарласан боловч зарагдаагүй, байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй байна.

Тус байгууллагын албан хаагчдын хэрэгцээнд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, ариутгал, халдаргүйжүүлэлтийн 69.7 сая төгрөгийн хэрэгслийг ТБОНӨБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасны дагуу гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэн, худалдан авсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,015.0 сая төгрөгийн 14 орлогын гүйлгээ, 213.5 сая төгрөгийн зарлагын 15 гүйлгээ, 174.4 сая төгрөгийн 11 худалдан авах ажиллагаа, 205.6 сая төгрөгийн өмч хөрөнгө, төсөв зарцуулах 28 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад тайлант онд зохион байгуулсан 26.7 сая төгрөгийн 3 худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулаагүй ба 160.2 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 58.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 9 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын Ханги боомтын үйл ажиллагааны чиг үүргийг 2022 онд гаалийн байгууллагад шилжүүлж байгаатай холбоотойгоор 2022 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл, хөрөнгө хөдөлгөөнд чиглэсэн аудитын нэмэлт горимыг гүйцэтгэх нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.9 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 4 зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад дараах алдааг залруулан бүртгэсэн. Үүнд,

- Бичиг хэрэг, тээвэр шатахуун, эм бэлдмэл, урсгал засварын нийт 1.9 сая төгрөгийн зардлыг хоол хүнс, дотоод албан томилолт, шуудан холбооны зардалд буруу ангилан бүртгэсэн байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд жилийн эцэст төвлөрүүлсэн үлдэгдэл болох 48.5 сая төгрөгийн дүнгээр улсын төсвөөс олгосон санхүүжилт болон төвлөрүүлэх шилжүүлэг дансны зардлыг бууруулж тусгасан байна.

Аудитаар залруулагдаагүй 4 алдаа, зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлсэн. Үүнд,

- Ахмадын сангийн ажил, гүйлгээ, үлдэгдлийг байгууллагын санхүүгийн тайланд тусгаж, орлого, зардлын гүйцэтгэл, үлдэгдлийг сангийн хөрөнгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд, мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 6.5 сая төгрөгөөр, зардлыг 5.1 сая төгрөгөөр, санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 29.6 сая төгрөгөөр тус тус тусгасан байна. Иймд ахмадын сангийн орлого, зарцуулалтын гүйлгээ, хөрөнгийн үлдэгдлийг байгууллагын санхүүгийн тайланд тусгахгүй байх.

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 53 нэр төрлийн 85.7 сая төгрөгийн 96 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Эдгээр хөрөнгийг актлах, эсхүл дахин шинээр үнэлгээ тогтоож ашиглах асуудлыг шийдвэрлэх.
- Шилэн дансны цахим системд тайлант онд зохион байгуулсан 26.7 сая төгрөгийн 3 худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулаагүй ба 160.2 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, 58.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулах 9 тушаал шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна. Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг мөн заалтад тусгасан хугацаанд байршуулж байх.
- Албан хаагчдын цалингаас суутгасан суутгалыг цалингийн өглөг дансанд тусгахгүйгээр бүртгэсэн байна. Мөн цалингийн урьдчилгааг олгохдоо цалингийн өглөг дансанд бүртгэсэн байна. Уг алдааг аудитын явцад залруулсан ба цаашид Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1 дүгээр хавсралтын 3.6-д заасны дагуу цалин хөлсний бүртгэлийг хөтлөх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	6	1.9	2	1.9	-	-	-	-	4	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		6	1.9	2	1.9	-	-	-	-	4	-